

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2027 ОНД БАРИМТЛАХ БОДЛОГЫН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан зорилго, зорилтыг тухайн жилд хэрэгжүүлэх, төсөв, санхүүгийн эх үүсвэрийг тусгасан төсөл, арга хэмжээ бүхий төлөвлөлтийн баримт бичиг байхаар хуульчилсан бөгөөд Улсын Их Хурлын 2025 оны 109 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зорилготой.

Монгол Улсын Засгийн газрын “ЧӨЛӨӨЛБЭ” санаачилга, эдийн засгийн чөлөөлөлт, эрх зүй, дүрэм журмын чөлөөлөлт, ногоон хөгжлийн чөлөөлөлт, авлигын эсрэг чөлөөлөлт зэрэг эрх чөлөөний дөрвөн зам, дөрвөн чөлөөлөлтийн бодлогыг ажил хэрэг болгон үр дүнтэй хэрэгжүүлнэ.

1. Зээлийн хүүг бууруулж, санхүүгийн зах зээлийг өрсөлдөөнтэй болгон төрийн оролцоог багасгаж, хувийн хэвшлийг дэмжих, бизнесийн орчныг тогтвортой эрх чөлөөтэй болгож, татвар, төсвийн шинэчлэлийг хийж, ажил эрхлэлт, үйлдвэрлэлийг дэмжин, болзошгүй эрсдэлийг хохирол багатай даван туулах үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх бүхий эдийн засгийн чөлөөлөлтийг хэрэгжүүлнэ.

2. Зөвшөөрлийн тогтолцоог хялбарчлан, төрийн үйлчилгээг цахимжуулж, төрийн албаны бүтцийг шинэчилж, шийдвэр гаргалтыг оновчлон хүнд суртлыг бууруулж, суралцагчийг мэдлэг, ур чадварын хоцрогдлоос чөлөөлж, эрүүл мэндийн тогтолцоог шинэчилж, ил тод болгон эрх зүй, дүрэм журмыг чөлөөлнө.

3. Эрчим хүчний хараат байдлыг бууруулан, сэргээгдэх эрчим хүчний тархмал эх үүсвэр, айл өрхийн нарны хавтан зайн хураагуур, бага оврын нарны эх үүсгүүрийг нэмэгдүүлж, ногоон дэд бүтцийг хөгжүүлэн, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх шинэ боломжийг бий болгох, ногоон дата төв байгуулах, ногоон хөгжлийн чөлөөлөлтийг хэрэгжүүлнэ.

4. Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжиж, үндэсний хиймэл оюуныг хөгжүүлж, өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалтыг нэвтрүүлж, цахим засаглал, ил тод байдлыг бодитоор нэмэгдүүлж, хариуцлагын механизмыг сайжруулан, шударга ёсны тогтолцоог бэхжүүлэн хууль давсан журмуудыг үе шаттайгаар бууруулж авлигын эсрэг чөлөөлөлтийг хэрэгжүүлнэ.